

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ОНЦЛОХ АЖЛЫН МЭДЭЭ

2022.02.11

Хараат

Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл, үр бүтээл гаргаж бусдыгаа манлайлан ажилласан зарим иргэдийг сар шинийн баярыг угтан Ерөнхийлөгч, ЗГ-ын шагнал, аймгийн шагнал, сумын шагналаар шагнаж урамшууллаа. 2020 оноос хойш Ковид-19 халдварын улмаас олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хязгаарласантай холбогдуулан шагнал гардуулах ажиллагааг өнөөдөр буюу 2022.01.26-ны өдөр халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгууллаа. 2019 оноос хойш олгогдоогүй байсан зарим шагналыг гардуулан өглөө. Мөн энэ үеэр сумын Ахмадын хороонд 2020, 2021 онд үйл ажиллагаагаар санаачлагатай сайн ажилласан ахмадын хороогоор шалгарсан шагналыг дарга Д.Наранцэцэгт гардуулав.



2021 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр сумын аварга /Мянгат/ малчин болсон 3-р багийн малчин Д.Доржмандал, 4-р багийн малчин О.Цэрэнсодном нарт хүндэтгэл үзүүллээ.



"Буян үйлдэгч" хэмээх усан БАР жилийн сар шинийн баярын босгон дээр Дэлгэрэх зам 2-р багийн малчин Батсуурийн Баянмөнх "УЛСЫН АВАРГА МАЛЧИН"-аар шалгарсан билээ. Шагналыг ХХААХҮ дэд сайд Г.Батсуурь, Аймгийн ИТХ-ын дарга С.Од-Эрдэнэ нар гардуулсан ба энэ үеэр сумын Засаг дарга Д.Буджав сум орон нутгийн зүгээс баяр хүргэж, хүндэтгэл үзүүллээ.



"Алтан төл"-ийн эздэд Усан бар жилийн шинийн 5-ны билэгт сайн өдөр Монголын үндэсний олон нийтийн радиогийн шагнал "Алтан төл"-ийн эзнээр шалгарсан малчдад МҮОНР-ийн орлогч захирал н.Бат-орших, Таван эрдэнэ нэвтрүүлгийн редактор н.Цогт-Эрдэнэ, МҮОНР-ийн зөвлөх н.Наранмандах нар малчны хотонд нь шагналыг гардуулав. Энэ үеэр сум орон нутгийн зүгээс малчдад баяр хүргэж хүндэтгэл үзүүллээ. Хараат багийн малчин Я.Батдорж, Д.Одбаяр нарын гэр бүл Алтан төл /ишиг/, Замын улаан багийн малчин Ц.Баатарцогт, Д.Мөнхзул нарын гэр бүл Алтан төл /хурга/-ны эзнээр тус тус шалгарсан билээ.



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР